



ДУНДГОВЬ АЙМАГ
БАЯНЖАРГАЛАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 07 өдөр

Дугаар 1/43

Аргатай

Ресторан, буудлын үйлчилгээ эрхлэх
төсөлд зээл олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 “б”, 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дугаар тогтоол, Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 02 тоот тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төсөл сонгон шалгаруулах хорооны 2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн хурлын шийдвэрээр Хоршоог хөгжүүлэх сангаас “Тааны говь ХХК /3431002/-д “Ресторан, буудлын үйлчилгээ ” эрхлэх төслийн санхүүжилт болох 50,000,000 (Тавин сая) төгрөгийг аж ахуйн нэгжийн харилцах дансанд төвлөрүүлэхийг нягтлан бодогч (Э.Хандсүрэн)-д даалгасугай.

2. Сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлт тайлагналтад хяналт тавьж ажиллахыг Хоршоог хөгжүүлэх сангийн хяналтын зөвлөлд даалгасугай.

3. Зээлдэгч иргэдийн зээлийн эргэн төлөлт, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршоо хариуцсан мэргэжилтэн (Э.Сувд)-д үүрэг болгосугай.

